



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 6/34

Хэрлэн сум

Ж.Туяаг ажилд түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл, 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”, Засгийн газрын 2022 оны Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн үйлчлэгч У.Ганцэцэг нь жирэмсний болон амаржсаны амралт авсан тул Жамбалжамцын Туяаг 2023 оны 3 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн үйлчлэгчийн ажилд түр томилсугай.

2. Ж.Туяагийн үндсэн цалинг ТҮ-1 зэрэглэлээр тогтоон, 565,277 (таван зуун жаран таван мянга хоёр зуун далан долоо) төгрөгөөр тооцож олгохыг Нягтлан бодогч (Э Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ж.Туяад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР